



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/479

Булган сум

Аялал жуулчлалын тоглолт,
эвент үйл ажиллагаанд оролцох уран бүтээлчдийн
зардалд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аялал жуулчлалыг хөгжүүлэх, дотоод болон гадаад жуулчдын сонирхлыг татах, иргэд, хүүхэд, залуучуудын идэвхтэй оролцоог дэмжих эвент үйл ажиллагааны урлагийн тоглолтод Улаанбаатар хотоос оролцох уран бүтээлчдийн зардлыг хавсралтаар баталсугай.

2. Эвент үйл ажиллагааны урлагийн тоглолт, соёл урлагийн арга хэмжээг шинэлэг, бүтээлч байдлаар зохион байгуулахыг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга (Г.Алдармөнх), үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган, хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг) нарт үүрэг болгосугай.

3. Шаардагдах зардлын 34,300,000 (гучин дөрвөн сая гурван зуун мянга) төгрөгийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн Булган аймаг, “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчийн үйлдвэрийн газрын 2025 онд хамтран ажиллах төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010674

Аймгийн Засаг даргын 2025 оны
07 дугаар сарын 07-ны/ний өдрийн
А.Д.А.С. дугаар захирамжийн хавсралт



Эвент үйл ажиллагааны урлагийн тоглолтод оролцох уран бүтээлчдийн төсөв

Д/д	Зардлын нэр	Нийт үнэ
1	2	3
1	Урлагийн тоглолтод оролцох уран бүтээлчдийн зардал	34,300,000
	Нийт	34,300,000